



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 07 өдөр

Дугаар А/СНА

Булган сум


Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны II/04 дүгээр тогтоолоор баталсан аймгийн Засаг даргын “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.2.4.1, аймгийн Засаг даргын 2023 оны А/112 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Боловсрол, шинжлэх ухааны газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Өвөр Монголын Өөртөө Засах Орны Ордос хотын “Хатан ухаан бийрэн бичлэг” ТББ-тай байгуулсан хамтын ажиллагааны хүрээнд Булган аймгийн багш ажилчдыг “Миний Монгол-2025” бийрэн бичлэгийн технологийн сургалтад оролцоход дэмжлэг үзүүлсүгэй.

2.Дэмжлэг үзүүлэхэд шаардагдах 500,000 (таван зуун мянга) төгрөгийг “Шинэ багш” хөтөлбөр, төлөвлөгөө хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагай)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ